

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
/УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ/**

1/30/2017

2016 оны жилийн эцэс

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах нэгж	Хэрэгжилт	Яамны үнэлгээ	Тайлбар
Тэргүүлэх зорилт №1. Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.						
1.1. Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах, тогтворжуулах хөтөлбөр боловсруулна.	1	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх	ТЗУГ	Уул уурхайн салбараас хэрэгжүүлэх "Алт-2" хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх, техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг бүх талаар дэмжиж, хэрэгжилтийг эрчимжүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах, нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах, Тавантолгойн ордод түшиглэн олборлон баяжуулах үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулах хэлэлцээрийг эцэслэн гэрээг байгуулж, хөрөнгө оруулалт орж эхлэх нөхцөлийг бүрдүүлэх, Гацууртын алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг арга хэмжээнүүдийг боловсруулж, УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр", Засгийн газрын 2016 оны 208 дугаар тогтоолоор батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө"-нд тус тус тусгуулан батлуулсан.	30	
1.4. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.	7	Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдалд зорилтот болон хэсэгчилсэн мониторинг хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах	ХШҮДАГ	Эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдалд мониторинг хийх талаар холбогдох судалгааг хийж байна.	10	
1.18. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулна.	1	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, хүндрэл, чирэгдлийг бууруулах, шуурхай байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ТЗУГ	Нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан иргэн, ААН, байгууллагад хууль тогтоомжид заагдсан эрх үүргийн дагуу холбогдох үйлчилгээ үзүүлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, мэдээ, мэдээллийг шуурхай хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор "Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг ТНБД-ын тушаалаар батлуулан хэрэгжүүлж ажилласан. Мөн харъяа агентлагийн хэмжээнд мөрдөгдөж буй зарим төрлийн үйлчилгээний журмыг /Тусгай зөвшөөрлийн өргөдөл хүлээн авах бүртгэх/ шинэчлэн батлуулахад арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч хяналтыг тавьж ажиллаж байна.	10	

1.24. “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	1	Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийг боловсруулж, хэрэгжүүлэх	УУБГ	Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах 3 хувилбар бүхий санал боловсруулж, ордыг олон улсын консерциумтай хамтарсан хэлбэрээр ашиглах нь оновчтой гэсэн санал гаргасан. - Тавантолгойн ордыг дэд бүтцийн хамт иж бүрнээр нь ашиглалтад оруулах талаар хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулах ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр захирамжаар шинээр байгуулагдаж хэлэлцээр хийгдэж байна. -Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглахтай холбогдон, Уул уурхайн яам /Эрдэнэс тавантолгой ХК/ болон Япон улсын НЕДО байгууллага /Нагата инженеринг/ хамтран Тавантолгойн ордыг түшиглэн нүүрсийг хуурай аргаар баяжуулах туршилтын үйлдвэр байгуулах тухай санамж бичгийг байгуулсан ба уг төслийн ажлыг тус яам үргэлжлүүлж байна. -Төслийн үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх талаарх хууль эрхзүйн орчны судалгааг хийж Сангийн яам болон Татварын ерөнхий газарт санал боловсруулж хүргүүлэхээр бэлтгэсэн.	10	
	2	Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	УУБГ	Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтыг явуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан ба Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт буюу төслийн 2 дахь шатны ажлыг эхлүүлж, туслан гүйцэтгэгч “РедПат” ХХК-д тэсэлгээний тусгай зөвшөөрлийг Уул уурхайн сайдын /хуучнаар/ 2016 оны А/54 тоот тушаалаар шинэчлэн /Тусгай зөвшөөрлийн дугаар №230/ олгож шийдвэрлэсэн. Далд уурхайн ажил графикайн дагуу явагдаж байна.	10	
	3	Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх	УУБГ	“Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр”-ийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж хийх шинжээчдийн хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны А/62 дугаар тушаалаар байгуулан ажлын хэсгийг ахлан ажиллаж, шинжээчдийн нэгдсэн дүгнэлтийг гаргаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	10	
Тэргүүлэх зорилт №2.1. Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна.						
2.1. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	1	Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан гаргах	ХҮБГ	Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан гаргахаар ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ болон УУХҮЯ-ны ХҮБГ хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна	10	

	2	Үйлдвэржилтийн газрын зураг дээр үндэслэн хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр баталж хэрэгжүүлэх	ХҮБГ	Үйлдвэржилтийн газрын зураг дээр үндэслэн хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр баталж хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ болон УУХҮЯ-ны ХҮБГ хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна	10	
2.4. Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлнэ.	1	Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын ашигт ажиллагаа, үр ашгийг нэмэгдүүлэх зорилго бүхий зохицуулалтын оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх	УУБГ	Сангийн яам, "Эрдэнэс Монгол" ТӨХХК-наас санал ирүүлээгүй байна.	/-/	
2.5. Томоохон төслийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.	1	Томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгах, хүүг бууруулах байдлаар зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх боломжийг судлан үзэж, оновчтой арга хэлбэрээр шийдвэрлэх	ХҮБГ	2018-2020 онд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ тул УУХҮЯ-ны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй.	/-/	
2.8. Бараа бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгахад Стандартчилал, тохирлын үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх, хэрэглэх, ашиглах механизмыг оновчтой болгоно.	1	Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт удирдлагын тогтолцооны ISO 9001, ISO 14001, ISO 50001, OHSAS 18001 зэрэг стандартуудыг нэвтрүүлснийг гэрчилгээжүүлэх, дэмжлэг үзүүлэх	БХЗГ	Стандартын Үндэсний хорооны гишүүнээр Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Даваадорж ажиллаж байна. Мөн уул уурхайн техникийн хорооны гишүүнээр ажиллаж байна. 2017 онд хороо хуралдаагүй болно.	/-/	
2.9. Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгаж, аажмаар бууруулах бодлого баримтална.	1	Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгах, бууруулах замаар бүтээгдэхүүний өртгийг багасгах бодлого хэрэгжүүлэх	БХЗГ	Үндсэн хэрэгжүүлэгч ЭХЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна.	/-/	
2.17. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.	1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах	ТБГ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13 өдрийн А/06 дугаар тушаалаар Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулаад байна.	10	

2	Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний нөхцөлийг сайжруулах, шатахууны үнийг олон улсын биржийн үнэтэй уялдуулан зохицуулах	ТБГ	Импортлогч аж ахуйн нэгжүүд болон ОХУ-ын “Роснефть” компанийн хооронд 2014 онд байгуулсан 5 жилийн хугацаатай хамтран ажиллах ерөнхий гэрээнд шатахууныг тогтвортой тасралтгүй ханган нийлүүлэх, төлбөр тооцоог зөвхөн ам.доллараар хийхээр тусгасан. Тус гэрээнд тухайн сарын хилийн үнийг өмнөх сарын Сингапурын бирж дээрх үнийн дундажаас хамааруулан тусгай томъёоллоор тооцохоор тохирсон. 2017 онд уг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан үнэ тооцох томъёолол, нөхцөл, нийлүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх талаар холбогдох талуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.	10	
3	Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогыг баримтлах	ТБГ	2016 оны 7 дугаар сараас төгрөгийн ханш огцом сулралт, арилжааны банкны зээлийн хүүгийн нэмэгдэл, шатахууны хилийн үнийн өсөлттэй холбоотойгоор шатахууны жижиглэнгийн үнэ өсөх нөхцөл байдал үүссэн тул татварын зохицуулалт хийж, үнийг тогтвортой байлгах талаар арга хэмжээ авсан. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 15 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. Шинэчлэн байгуулагдсан “хамтарсан Зөвлөл”-ийн хуралдааныг тухай бүрт хуралдуулж холбогдох зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлж Засгийн газрын 2016 оны 109 дүгээр, 166 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүдийн боомтоор имдортлож буй автобензин, дизелийн түлшинд ногдуулах онцгой албан татварыг бууруулж, баруун болон зүүн бүсийн боомтуудаар импортлож буй бүтээгдэхүүний татварыг тэглээд байна. Ингэснээр алслагдсан бүс нутгийн шатахууны жижиглэнгийн үнийг төвийн бүстэй ойролцоо буюу 30-80 төгрөгний зөрүүтэй байх нөхцлийг бүрдүүлсэн.	50	

4	Улсын болон компанийн нөөцийг бүрдүүлэх	ТБГ	<p>Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 13.1-д "Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нь улсын болон компанийн нөөцөөс бүрдэнэ" гэж заасан байдаг. Монгол Улсын 2012 оны төсвийн хөрөнгө болон Засгийн газрын эрсдэлийн сангийн хөрөнгөөр бүрдүүлсэн 12.7 мянган тонн улсын нөөцийн шатахууныг аж ахуйн нэгжүүдтэй хадгалалтын гэрээ байгуулан хадгалуулж ирсэн. Гэвч Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2016 оны төсвийн багцад хадгалалтын зардал тусгагдаагүй тул ААН-үүдтэй сэлгэх гэрээ байгуулан хадгалуулж байна.</p> <p>Засгийн газрын 2015 оны 412 дугаар тогтоолоор 2016 оны газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 84720 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнээс доошгүй байхаар тогтоосон. Улсын хэмжээнд 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар газрын тосны бүтээгдэхүүний ердийн хэрэглээний 50 хоногийн нөөцтэй байна.</p> <p>Мөн газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээнд гарсан өөрчлөлттэй уялдуулан 2017 онд бүрдүүлэх компанийн нөөцийн хэмжээг Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 147 дугаар тогтоолоор 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээ буюу 81900 тонн болгон шинэчилсэн.</p>	70	
5	Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох	ТБГ	<p>Өнөөгийн байдлаар Улсын хэмжээнд 1210 шатахуун түгээх станц, 367086 м3 багтаамжтай 1084 агуулах, сав бүртгэлтэй байгаа ба энэ онд Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцуудын улсын үзлэгийг зохион байгуулж, бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн, мэдээллийг нэгтгэхээр төлөвлөж байна. Уг мэдээллийг үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох зохицуулалтыг аж ахуйн нэгжүүдтэй хамтран хийхээр төлөвлөж байна.</p>	10	

6	Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах	ТБГ	<p>Улаанбаатар хот болон томоохон суурин газруудад 2017 оноос автобензин, дизель түлшний чанарыг Евро-5 стандартад шилжүүлэхээр төлөвлөөд байна. Автобензин, дизель түлшний Евро-5 стандартын жишигт нийцсэн MNS стандартын төсөл боловсруулж, Стандарт, хэмжилзүйн газрын “Газрын тос, байгалийн хийн техникийн хороо”-ны 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Өнөөгийн байдлаар тус төсөл Стандартчиллын Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.</p> <p>- АНУ-ын NFPA-58 стандарт, дүрмийн орчуулгад үндэслэн Монгол орны цаг уур, ахуй, соёлын онцлогт тохирсон MNS стандартын төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж эхлээд байна.</p> <p>-“Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлын норм”, “Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлыг тооцоолох аргачлал”-ын төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулсан. “Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлын норм”-ыг Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан ба “Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлыг тооцоолох аргачлал”-ыг батлуулахаар ажиллаж байна.</p>	10	
7	Гашуун сухайт, Ханх, Хавирга зэрэг боомтуудаар бүтээгдэхүүн тогтмол импортлох ажлыг эхлүүлэх, улмаар тээвэр ложистикийн зардлыг бууруулах, өртгийг багасгах судалгаа хийх	ТБГ	<p>Гадаад хэргийн яам, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн газар хоорондын байнгын зөвлөлдөх Ажлын хэсгийн 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн гуравдугаар хуралдааны үеэр Монголын талаас Хавирга, Гашуунсухайт, Шивээхүрэн зэрэг боомтоор Хятад улсаас шатахуун нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Хятадын талаас холбогдох боомтуудад шаардлагатай нөхцлийг бүрдүүлсэн тохиолдолд, үйл ажиллагааг явуулах боломжтойг илэрхийлсэн. - Мөн МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын 2016 оны 05 дугаар сарны 5, 6-ны өдрүүдэд зохион байгуулагдсан XIV хуралдааны үеэр Монгол талаас Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга зэрэг боомтоор шатахуун импортлох хүсэлтийг Хятадын талд тавьсан ба талууд судалж үзэхээр тохиролцов.</p> <p>-Гаалийн ерөнхий газрын Хөвсгөлийн төлөөлөгч болон Бурядын гаалийн газрын төлөөлөгчдийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ний өдөр “Ханх” боомт дээр хийсэн уулзалтаар тус боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох боломжийн талаар санал солилцсон. Уг асуудлаар тус яам нь бодлогын хүрээнд дэмжиж ажиллах тухайгаа Улан-Үдийн консулын газарт мэдэгдээд байна.</p>	10	

Тэргүүлэх зорилт №2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.

2.48. Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.	1	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Зарим барааны импортын гаалийн татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, ТБОНӨХБАҮХА тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	ХҮБГ	"Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөр"-ийн хүрээнд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна.	10	
	6	"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг боловсруулан батлуулах	ХҮБГ	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/157 дугаар тушаалаар "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр"-ийг боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Монгол Улсад хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн танилцуулгыг ажлын хэсэг боловсруулан Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний хуралдаанд хэлэлцүүлсэн. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2016 оны 60 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах тухай санал гарсны дагуу ажлын хэсэг уг баримт бичгийг боловсруулж дахин Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.	30	
	7	"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	ХҮБГ	"Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр"-ийг боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалт, байгуулах үйлдвэрүүдийн товч танилцуулгыг боловсруулсан.	30	
Тэргүүлэх зорилт №2.3. Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.						
2.59. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.	1	Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулах	ГБГ	2016 онд Тогоо хайрхан-50, Улаанбадрах-50, Баяндалай-50, Онц уул-50, Эмээлцэгийн нуруу-50 төслүүдийн үр дүнг ЭБМЗ-өөр хэлэлцэн хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 34.6%-ийг хамруулсан. Тайлант онд суурин болон хээрийн судалгааны ажилтай 23 төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Шинээр хэрэгжүүлэх 10 төслийн гүйцэтгэгийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлснээр нутаг дэвсгэрийн 5%-д ажил үргэлжлэн хэрэгжиж байна. 2017 онд нутаг дэвсгэрийн 1.5%-д төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажилласан.	10	

2	Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэх	ГБГ	Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлаар нутаг дэвсгэрийн 86%-ийг бүрэн хамруулсан бөгөөд 2016 онд УГЗ-200-Дорнод Монгол-VI, Дорнод Монгол-VII, Төв Монгол-V, Төв Монгол-VI төслүүдийн суурин боловсруулалтын ажлыг хэрэгжүүлж дууссан. Үр дүнгийн тайланг 2017 онд хүлээн авснаар 100% хамрагдаж дуусна. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.	10	
3	Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх	ГБГ	Ховд, Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутгийн өмнөд хэсгүүдийг хамарсан талбайд агаарын геофизикийн 5-н сувгийн Алтай-1, Алтай-2 төслүүдийн хээрийн судалгааны ажлыг хэрэгжүүлж дууссан. Төслүүдийн хээрийн судалгааны анхдагч материалыг хүлээн авсан. Үр дүнгийн тайланг 2017 онд хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 13% хамрагдана. 2016 оноос шинээр Ховд, Баян-Өлгийн аймгийн нутгийн зарим хэсэг буюу 104044 км.кв талбайд Ховд-1 төслийг хэрэгжүүлж эхэлсэн.	10	
4	Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геохимийн судалгаа хийх	ГБГ	Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулах зорилгоор төслийг эхлэх бэлтгэл ажлыг ханган ажилласан. Үүнд, төслийн ажлын зорилго, зарцуулагдах төсөв, геологийн даалгавар зэргийг бэлтгэсэн.	10	
5	Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологийн болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх	ГБГ	Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологийн нөхцлийг нарийвчилан үнэдэх зорилгоор 1:10000-1:250000-ны масштабын хэмжээнд судалгааны ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласан.	10	
6	Эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан сэдэвчилсэн судалгааны төсөл хэрэгжүүлэх	ГБГ	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Монгол орны баруун хэсэгт ашигт малтмалын томоохон орд олох зорилгоор Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай аймгуудын нутгийн хэмжээнд Баруун Монголын цул сульфид-2013 төслийг хэрэгжүүлж эцсийн суурин боловсруулалтын ажилтай танилцаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажилласан. Сансрын зургийн тайлалт, Газрын ховор элементийн металлогени, Монгол орны металлогени зэрэг төслүүдийн суурин боловсруулалтын ажлууд хийгдсэн. Үр дүнгийн тайланг 2017 онд хүлээн авна. Геологийн судалгааны ажилд орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах, ОУ-ын хэмжээнд хүргэх зорилгоор ASTER төрлийн хиймэл дагуулын мэдээллийг боловсруулах Сансрын зургийн тайлалт-2013 төслийн суурин боловсруулалтын ажилтай танилцсан.	30	

	7	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул судалгаа, ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	БХЗГ	Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2016 оны 4 сард УИХ-д өргөн барьсан.	30	
	9	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулах	БХЗГ	Монгол улс, БНФУ-ын хөрөнгө оруулалттай "Арева майнс" ХХК-ийн нэр дээр цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг олгох ажлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, ордуудыг эзэмшигч хамтарсан компанитай "Орд ашиглах гэрээ"-г байгуулах ажлыг зохион байгуулсан. "Гурван сайхан" ХХК-д цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг олгож "Орд ашиглах гэрээ"-г байгуулуулсан бөгөөд эдгээр ордуудыг эзэмшигч компаниудын хувьцааны Монголын төрд ногдох хувь эзэмшлийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.	30	
2.60. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	1	Үндэсний геологийн алба байгуулахдаа хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын ижил төстэй байгууллагуудын талаар иж бүрэн судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж, ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах, үйл ажиллагааг эхлүүлэх	ГБГ	Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны төслөөс Геологийн албадын олон улсын туршлагын талаар хийсэн судалгааны тайланг эхний байдлаар Уул уурхайн яамны "Монгол Улсад Үндэсний Геологийн алба байгуулах" Ажлын хэсэгт танилцуулсан. УУЯ-ны Стратеги, бодлого, төлөвлөлтийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баянмөнхийн хүсэлт /хуучнаар/-ээр Швед, Финлянд, Хятад, Баруун Австрали, Канад, Бритиш Колумб, Ботсвани, Намиби, Чили, Вьетнам, Чех, Япон, АНУ зэрэг орнуудын геологийн албадын талаарх судалгааны тайлантай танилцсан. Мөн түүнчлэн Монгол Улсын геологийн мэдээллийн удирдлагын өнөөгийн нөхцөл байдлын талаар хийсэн судалгаа болон Геомэдээллийн санг эрхлэх журмын төслийг Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕР)-ийн зөвлөх боловсруулж багийн гишүүд санал зөвлөмж өгсөн.	10	
	2	Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах, мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг боловсруулах, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох	ГБГ	Үндэсний геомэдээллийн санг баяжуулах ажлын хүрээнд геологийн төв архивын материалуудыг цэгцлэж олон нийтийн хэрэгцээнд хүргэх зорилгоор Геомэдээллийн сан-2013 төслийг хэрэгжүүлж геологийн 1:500000, геоморфологийн 1:1000000, гидрогеологийн 1:500000-ны масштабын зургийг нэгтгэх, хээрийн судалгааны ажлын анхдагч материал цэгцлэн бүртгэлжүүлэх төслийг хэрэгжүүлсэн. Үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн хүлээн авах бэлтгэл ажлыг ханган суурин боловсруулалтын ажилтай танилцсан. Үр дүнг 2017 онд хүлээн авна. Геологийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам боловсруулахаар ОХУ, Австрали Улсын туршлагыг судалсан. Геомэдээллийн сан хөтөлбөр боловсруулахаар судалгааны ажлыг эхлүүлсэн.	10	

2.61. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.	1	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	ГБГ	Үүсмэл ордын зохицуулалтын талаар АМТХ-д нэмэлт оруулах төслийг УИХ-аар хэлэлцүүлэн 2016 оны 11-р сарын 10-нд батлуулсан. Тус хуульд 4.1.27, 4.1.28, 9.1.14, 9.1.15, 26.7, 26.10, 26.11, 47 ³ -р зүйл, 48.13, 48.14, 53.6, 56.7-оор зохицуулалтуудыг нэмэлтээр оруулсан.	30	
	2	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах	УУБГ	Уул уурхайн тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах Ажлын хэсгийн тушаалыг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/99 дугаар тушаалаар батлуулсан. Уул уурхайн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан 2016 оны 12 сарын 26-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүйн сайдаар батлуулсан. Уг хуулиар Ил тод, хариуцлагатай уул уурхайн тогтолцоог олон улсын чиг хандлагад нийцүүлэн бүрдүүлэх зохицуулалт хийснээр салбарын хөгжлийн талаарх олон нийтийн ойлголт, итгэл үнэмшил нэмэгдэж, Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн аргаар зүй зохистой ашиглах, улмаар байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэдийн болон хөрөнгө оруулагчдын өөр хоорондын харилцаа сайжрах, нийгэм, эдийн засагт оруулах үр өгөөж нэмэгдэх, төр, нийгмийн байгууллага, хувийн хэвшил, орон нутаг, иргэдийн олон талт харилцаа оновчтой зохицуулалттай болох зэрэг эерэг үр дагавар бий болно гэж тооцоолж уул уурхайн ил тод байдлын зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.	30	
	3	Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах	ГБГ	Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг ХЗЯ /хуучнаар/ хамтран боловсруулсан. Үзэл баримтлалыг ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлж хуулийн төсөл боловсруулахаар тогтсон. УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны Б/113 дугаар тушаалаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, төслийн нэгжийг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.	10	
	4	Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	БХЗГ	Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд төслүүдийн судалгаа хийж, аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийхээр төлөвлөж байна.	10	
	5	Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын төслийг хэрэгжүүлэх, үр дүнгийн тайланг хүлээн авах	ГБГ	БНЧех Улсын геологийн албатай хамтран геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн "Монгол Алтай-50" төслийг хэрэгжүүлж үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн УУХҮС-ын 2017 оны А/02 дугаар тушаалаар жишигт нийцсэн гэж хүлээн авсан. -БНПольш Улсын Геологийн албатай хамтран Хасагт-50 төслийг хэрэгжүүлж үр дүнгийн тайланг дипломат шуудангаар хүлээн авч орчуулгын ажлыг хийж байна. -МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан "Хойт, төв, зүүн Азийн геологийн гүний процесс ба металлогени" төслийг үргэлжлэн хэрэгжүүлсэн. Төслийн суурин боловсруулалтын ажилтай танилцаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	30	

	6	Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орнуудаас ирүүлсэн саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ГБГ	БНХАУ-ын ӨМӨЗО-той хамтран геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн төсөл хэрэгжүүлэх саналыг хүлээн авч судалсан. Хамтарсан төслийг Өмнөговь аймгийн нутгийн зарим хэсэг буюу 5000 орчим км.кв талбайд геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийхээр тохирсон бөгөөд ҮАБЗ-өөс өгсөн чиглэлийн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг ЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхээр хуралдааны тэмдэглэл, танилцуулга, төслийн гэрээ зэрэг материалыг боловсруулсан.	10	
2.62. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.	1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийг ил тод, нээлттэй түгээх аргачлалын санал боловсруулах	ГБГ	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийсэн. Тусгай зөвшөөрлийг олгох ажлыг олон нийтэд ойлгомжтой, хялбар, мэдээллийн ил тод байхаар төлөвлөн цахим хэлбэрээр олгох аргачлалыг боловсруулсан.	30	
2.63. Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.	1	"Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого"-ыг шинэчлэн боловсруулах	ТБГ	УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Б/101 тоот тушаалаар Монгол Улсын Их Хурлын 2011 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого"-ын барим бичгийн хэрэгжилтийг дүгнэх, цаашид Газрын тосны салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. "Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого"-ын барим бичгийн хэрэгжилтийг дүгнэх ажил хийгдэж байна.	10	
	2	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	ТБГ	Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар УИХ-ын 2016-2020 онд хэлэлцүүлэх асуудлын жагсаалтанд тусгуулсан. 2017 оны УУХҮЯамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хуулийн төсөл боловсруулахаар тусган ажиллаж байна.	10	
	3	Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	ТБГ	Газрын тосны тухай хуулийн 7.1.4 "нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах: газрын тосны бүртгэл, тооцоо: газрын тосны салбарыг хөгжүүлэх сан: уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах" -т заасан санхүү бүртгэл, тооцоотой холбоотой журмын төсөл боловсруулахаар УУХҮЯамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хуулийн төсөл боловсруулахаар тусган ажиллаж байна.	10	

4	Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх	ТБГ	2016 онд 8,2 сая баррель буюу 1,11 сая тонн газрын тос олборлож, 8,0 сая баррель буюу 1,08 сая тонн газрын тос экспортолж, Улсын төсөвт 134,2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. 2017 онд Тосон-Уул-19-р талбайгаас 210 сая ам.доллар, Тамсаг-21-р талбайгаас 231 сая ам.доллар, БХГ-97 талбайгаас 11 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг тус тус хийж, 1,1 сая тонн тос олборлон экспортолж, улсын төсөвт 188 тэрбумыг төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	30	
5	Газрын тосны ордын дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх	ТБГ	УУЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД-ын 81 дүгээр тушаалаар Дорнод аймгийн Халхгол сумын нутагт 2013-2015 оны хооронд Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тамсаг XXI талбайн олборлолт нэмэгдүүлэх цооногийн байгууламж, 2013 оны тосны цооног 51ш, усны цооногийн байгууламж 11ш, 2014 оны тосны цооног 52 ш, усны цооногийн байгууламж 18ш, 7000м3-ын сав 2ш, гүний ус цэвэршүүлэх станц, бохир ус цэвэршүүлэх станц, 2015 оны тосны 105ш цооног, усны цооногийн байгууламж 49ш, 7000м3-ын сав 1ш, ус, тос ялгах байгууламж болон холбогдох барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс 2016 оны 6 дугаар сард ажиллаж, байгууламжийг хүлээн авсан. -УУХҮЯ-ны ТНБД-ын Б/55 дугаар тушаалаар Дорнод аймгийн Матад сумын нутагт 2013-2015 оны хооронд Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон-Уул XIX талбайн олборлолт нэмэгдүүлэх цооногийн байгууламж (2013 оны тосны цооног 47ш, усны цооног 22ш, 2014 оны тосны цооног 43 ш, 2015 оны тосны цооног 59ш, усны цооног 7 ш, 6ш тосны цооногийг ус шахалтын цооног болгон өөрчлөх), ТА19-91 үйлдвэрлэлийн хяналтын өрөөний инженерчлэл, ТА1-11 шинээр барих тос буулгах байгууламж, 1-9 тос дамжуулах станцын өргөтгөл, ТА-1-ийн шинэ ачилтын талбайг ашиглалтад оруулах Улсын комиссыг ажиллуулах ажлыг 2016 оны 10 дугаар сард зохион байгуулж, байгууламжийг хүлээн авсан.	50	
6	Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх	ТБГ	Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын тосны тухай хуулийн 8.1.8-д заасан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ыг боловсруулах Ажлын хэсгийг БОНХАЖ, Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ 2015.03.24-ний өдрийн 62/А-131 дугаар хамтарсан тушаалаар байгуулж төслийг боловсруулан БОНХАЖ-ийн сайдын /хуучин нэрээр/ зөвлөлийн хуралдаанаар 2015.11.11-ний өдөр хэлэлцүүлсэн. Журмын төслийг Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ зөвлөлийн хуралдаанаар нийт 2 удаа хэлэлцүүлэн УУС, БОНХАЖ-ын Сайдын /хуучин нэрээр/ хамтарсан тушаалаар батлуулж, журмын дагуу Хууль зүйн яаманд бүртгүүлэхээр хүргүүлсэн.	10	

